

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны ... дугаар
сарын . . .-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Цагийн хөлсний хэмжээ, олгох журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн 42.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн бүрэлдэхүүнд олгох цагийн хөлсний хэмжээг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан тухайн онд мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний нэг цагийн доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар баталсугай/тогтоосугай.

2.Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн бүрэлдэхүүнд цагийн хөлс олгох журмыг хавсралт ёсоор баталсугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т, цагийн хөлс олгох зардлын хэмжээг нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны жил бүрийн төсөвт тусгаж, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарты тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

Х.БУЛГАНТУЯА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2023 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн .../... дугаар тушаалын хавсралт

МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ЦАГИЙН ХӨЛС ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг зүйл

1.1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн 42.10-т заасан маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөл болон салбар зөвлөл (цаашид “зөвлөл” гэх)-ийн дарга, гишүүн, салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад хуралд оролцсон цагийг харгалзан цагийн хөлс олгоход энэхүү журмыг баримтална.

Хоёр.Цагийн хөлс олгох

2.1.Зөвлөлийн дарга, гишүүн, салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад хуралд оролцсон цагийг харгалзан энэ тушаалын 1 дэх хэсэгт заасан цагийн хөлсний хэмжээгээр хөлс олгоно.

2.2.Энэ журмын 2.1-д заасан хөлсийг цагаар тооцож олгох бөгөөд зөвлөлийн гишүүдийн хуралд оролцсон нийт цагийг бүртгэх, гишүүдэд цагийн хөлс олгох, тайлан гаргах ажлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

2.3.Цагийн хөлсийг зөвлөлийн гишүүдийн хуралд оролцсон цагийн нотлох баримтад тулгуурлан хөлс олгож байгаа эсэхэд Зөвлөлийн дарга хяналт тавьж ажиллана.

2.4.Зөвлөлийн гишүүдийн цагийн бүртгэл олон нийтэд нээлттэй байна.

Гурав.Бусад

3.1.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---